

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

ҮҮР ЦАЙЖ, ҮГЭЭГҮЙ НАРЫН
ЖАРГАЛЫН ЗАМ НЭЭГДЛЭЭ

Академич **Б. Ширэндэв**

Капитализмаас социализмд шилжин орох эрин үеийг нээсэн Октябрийн хувьсгал нь үр дүнгээрээ түүхэнд урьд өмнө гарч байсан аль ч хувьсгалаас эрс тэс ялгаатай социалист хувьсгал мөн. В.И. Ленин, Октябрийн хувьсгал бол «бусад орон ба ард түмнүүдийн аж амьдралд нөлөөлөх утгаараа, мөн түүнчлэн түүний зарим үндсэн шинж тэмдэг олон улсын хэмжээнд зайлшгүй давтагдах утгаараа олон улсын ач холбогдолтой юм»¹ гэжээ.

Октябрийн хувьсгалын үзэл санаа, нөлөөгөөр орон бүхний ажилчин ангиас нийгмийн эрх чөлөөнийхөө төлөө явуулсан тэмцлийн дунд коммунист ажилчны намууд үүсэн эгнээгээ өргөтгөж, колони ба хараат орны ард түмэн үндэсний эрх чөлөөнийхөө төлөө тэмцэлд босч их ялалтанд хүрсээр ирсэн билээ.

Орос улсын ажилчин анги, үй олон сая тариачин нар Лениний намын удирдлагын дор Аугаа их Октябрийн хувьсгалын ялалтыг хангаж хөрөнгөтний засгийг түлхэн унагасан билээ. Ажилчин тариачин ангийн шинэ Зөвлөлт төр улс орны үйлдвэрлэлийн гол багаж хэрэгслэлийг ард түмний мэдэлд шилжүүллээ. Зөвлөлт төр түүхэнд анх удаа социализмыг эхлэн байгуулж, улс орноо хүнд үйлдвэржүүлж, хөдөө аж ахуйгаа социалист ёсоор хоршооллох, соёл, шинжлэх ухаан, ардын боловсрол, урлаг утга зохиолыг хөгжүүлж, ард түмнийхээ материаллаг соёлын амьдралыг дээшлүүлэх талаар түүхийн ахар богино хугацаанд гарамгай ялалт, амжилтанд хүрч чадсан ажээ. Зөвлөлт төрийн Ленинч үндэсний бодлогын ачаар хаант засгийн үед дарлагдан мөлжигдөж байсан олон үндэстнүүд нийгэм улс төрийн тэгш эрхтэй болж, аж ахуй, соёл нь цэцэглэн хөгжиж, олон үндэстний ах дүү ёсны интернационалч зөвлөлт гэр бүл бүрэлдэн тогтов. Социалист энэ их өөрчлөлтийг хийж явуулахад хувьсгалаар эрх ямбаа алдсан дарлагч ангийн зүгээс удаа дараа хийсэн ангийн ширүүн эсэргүүцэл, тэмцэл, иргэний дайн, капиталист ертөнцийн өнгөлзлөг дайралтаас октябрийн хувьсгалаар байлдан олсон ялалтаа хамгаалах зэрэгтэй холбогдсон бэрхшээлийг зөвлөлтийн ард түмэн коммунист намынхаа удирдлагаар амжилттай даван туулсан юм.

Империализмын хамгийн харгис хүч Герман, Итали, зэрэг оронд фашистууд засгийн эрхийг булаан авч, Европын олон орныг түрэмгийлэн эзэлж, тэдгээрийн материаллаг баялагийг тонон дээрэмдэж, цэргийн хүч чадлыг ашиглаж, даян дэлхийд ноёрхлоо тогтоохыг эрмэлзэхдээ юуны өмнө Октябрийн орон ЗХУ-ын эсрэг бүх хүчээ дайчлан чиглүүлж, түүний нутаг дэвсгэрт хулгайн ёсоор гэнэт цөмрөн орсон билээ. Энэ хүнд үед Зөвлөлтийн ард түмэн нам, төрөө улам хүрээлэн нягтарч, эх орноо аврах шударга дайныг таван жилийн туршид баатарлагаар явуулж, фашистын Германыг ялан, дэлхийн II дайныг эцэс болгоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ.

Зөвлөлтийн улаан арми фашистын хүн олонтой, зэвсэг сайтай цэргийн хүчийг бут ниргэж, улмаар өргөн удам эх орноо булаан

1 В. И. Ленин зохиолууд, 4 дэх удаагийн хэвлэл, 31-р боть, 5 дугаар тал.

эзлэгчдээс чөлөөлөөд, Германы фашизмын дарлалд талхигдсан зовж байсан олон орны ард түмнийг чөлөөлөн аварч, дайны сүүлчийн шатанд Японы милитаристуудын гол хүчийг Зүүн хойд Хятадад бут ниргэсэн зэрэг нь дэлхий дахины түүх, шаштирт алтан үсгээр үүрд тэмдэглэгдсэн юм.

ЗХУ ба түүний холбоотнууд фашист Герман, милитарист Японы зэвсэгт их хүчийг ялж дийлсний үрээр Герман, Итали зэрэг улсуудад фашист дэглэм нуран унаж, харгис засаг халагдан, Европ, Азийн хэд хэдэн оронд ардын ардчилсан засаг төр тогтсоноор дэлхийн социалист систем бүрэлдэн буй болсон билээ. Үүний зэрэгцээ Ази, Африк, Латин Америкийн орнуудад үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн эрч хүчээ авч, колоничлол ба хараат дэглэмээс чөлөөлөгдөн, шинэ залуу тусгаар тогтносон улсууд буй болсны дотроос 20 орчим орон нь социалист чиг баримжаагаар хөгжиж байна.

Зөвлөлтийн ард түмэн коммунист намынхаа удирдлагын дор дайны уршгаар сүйрсэн улс ардын аж ахуйгаа богино хугацаанд амжилттай сэргээн босгож, урагшлан хөгжүүлсээр эдийн засаг, соёл, ард түмний ахуй байдлын хувьд шинэ их амжилтанд хүрч, зөвлөлт орон дэлхийн хүчирхэг, хөгжингүй их гүрэн болж чадлаа.

Зөвлөлт Социалист нийгэмд буй болсон эдийн засаг, шинжлэх ухаан, оюун санааны асар их чадавхийг ЗХУКН өндрөөр үнэлэн дүгнэж, түүнийг цаашид хэрхэн түргэн хугацаанд бүх талаар хэрэгжүүлэх вэ гэдэг асуудлыг марксист-ленинист онолын үүднээс боловсруулж шийдвэрлэн хэрэгжүүлж байна. ЗХУКН-ын Төв Хороо 1985 оны IV сарын бүгд хурлаараа улс орныхоо нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах стратегийг дэвшүүлээ. Нам улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг шинжлэх ухаан, техникийн дэвшлийн үндсэн дээр хурдасгах зорилгоор нийгмийн харьцаа, зохион байгуулалт удирдлагыг боловсронгуй болгох, социалист ардчиллыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, ажлын арга хэлбэрийг шинэчилж, аливаа нэгэн идэвхгүй, зогсонги, хуучирсан хандлагыг халж, бүхэнд шинээр сэтгэн, идэвхтэй хандаж, улс ардын аж ахуй, соёлын салбарын ажиллагааг хувьсгалчаар өөрчлөн, үйлдвэрийн бүтээгдэхүүний чанарыг дэлхийн тэргүүний түвшинд хүргэж, ард түмний аж байдлыг цаашид сайжруулахын төлөө зохион байгуулалт, үзэл суртлын өргөн далайцтай арга хэмжээнүүдийг авч явуулж байна.

ЗХУКН ингэж социализмын давуу талыг ашиглаж, мөн чанар, нэр хүндийг нь улам дээшлүүлж буй нь дэлхийн социалист систем, хувьсгалт хөдөлгөөн, энхийг эрхэмлэгч бүх хүчнийг баясган зоригжуулж байна. Хүнд аж үйлдвэр, хөдөө аж ахуйд дэвшилт техник, технологийг тууштай нэвтрүүлэн шинэчилж, улс ардын аж ахуйн бүх салбарыг биеэ даан ажиллуулж, өөрийгөө санхүүжүүлэх зорилгоор улсын үйлдвэрийн байгууллага (нэгдэл), машины үйлдвэрийн программ, хөдөө аж ахуйн иж бүрэн цогцолбор, шинжлэх ухаан, үйлдвэрийн нэгдлийг байгуулсан зэрэг олон тооны чухал арга хэмжээнүүдийг авч явуулж байна. Ардын боловсролын системийг өөрчлөн боловсронгуй болгох, боловсон хүчний бодлогыг боловсруулан сайжруулах, үзэл суртал, мэдээлэл, хэвлэлийн байгууллагуудын ажлыг чанаржуулах, нам, төр, олон нийтийн байгууллагуудын ажлын арга барилыг бүх талаар сайжруулах ба шинээр сэтгэл хөдөлмөрлөх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Эдгээрийг хэрэгжүүлэхдээ материаллаг үйлдвэр, оюун ухааны бүх салбарт нийгмийн шударга ёс, хүний хүчин зүйлийн чадвар, түүний ухамсрыг дээшлүүлж бүх ард

түмнийг нийгмээ удирдах ажилд өргөнөөр оролцуулж, хүн нэг бүрийн идэвхи санаачилга, шүүмжлэл, өөрийн шүүмжлэлийг өрнүүлж, нийгмийн амьдралын бүх хүрээнд эрүүл саруул уур амьсгалыг буй болгох талаар асар их ажил явагдаж байна. Намаас дэвшүүлсэн энэ шинэ урамтай арга хэмжээг Зөвлөлтийн бүх ард түмэн сайшаан дэмжиж, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө бүтээлч хөдөлмөр, шинэ шинэ санаачилгаа газар сайгүй оргилуулж байна. Энэ нь ЗХУКН-ын XXVI их хурлаас дэвшүүлсэн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх XII таван жилийн төлөвлөгөөний эхний жилийн төлөвлөгөөний биелэлтээс үзэхэд тодорхой байна. Жишээлбэл Зөвлөлтийн нийгэм, эдийн засгийг 1986 онд хөгжүүлэх төлөвлөгөө амжилттай биелэгдэж, нийгмийн үйлдвэрлэлийн бүх салбарт хөгжлийн хурдац дээшилж, улс ардын аж ахуйн гол салбаруудад нааштай ахиц гарч, нийгэм, соёлын байдлыг дээшлүүлэх талаар бодитой үр дүн гарч байна. 1986 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 39 миллиард, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн 17,5 миллиард рублиэр 1985 оныхоос тус тус давжээ.² Зөвлөлт нийгмийн амьдралын салбар бүхэнд гарч буй нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасгах, өөрчлөн байгуулах хувьсгалч үйл ажиллагаан нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудын цаашдын хөгжилд таатай үлгэр дууриал болж байна.

II

Азийн хоцрогдмол орнуудын нэг байсан Монгол Улс ардын хувьсгал ялснаас хойшхи өнгөрсөн 66 жилийн дотор олсон ялалт, амжилт бол Аугаа их Октябрийн социалист хувьсгалын шууд нөлөөний яруу тод илрэл, үр дүн мөн.

Монголын ард түмний сэргэлэн цовоо, шулуун шударга, тэргүүний дэвшилт үзэлтэй төлөөлөгч нар марксизм-ленинизмийн сургаалын утга агуулга, Октябрийн хувьсгалын үзэл санааг зөвөөр тусган авч чадаад феодал, колонийн давхар дарлалыг амсаж байсан ардынхаа тэмцлийг Октябрийн эх орон ЗХУ-тай холбож, түүнд түшиглэн Монгол орны чөлөөт хөгжлийн замыг нээсэн билээ.

Д. Сүхбаатар тэргүүтэй Монголын хувьсгалчид Октябрийн хувьсгалын үзэл санаагаар зэвсэглэн, ЗХУКН ба олон улсын коммунист хөдөлгөөний төв штаб-Коминтерний дэмжлэгт тулгуурлан, гадаад дотоодын дарлагчдын дэглэмийн хүнд хэцүү нөхцөлд хувьсгалт нууц бүлгэм, дараа нь Ардын намыг байгуулж «Тангарагийн бичиг», «Эрмэлзэх арван зүйл», «Монголын үнэн» хэмээх сонин, ухуулах бичгүүддээ өөрийн орны цаг үеийн байдлыг Октябрийн хувьсгалын үзэл санааны үүднээс дүгнэн цэгнэж, эзэрхэг түрэмгий ба феодалын эсрэг хувьсгалын зорилтыг томъёолон тодорхойлсон билээ. Дэвшүүлсэн зорилтуудыг биелүүлэхийн тулд Монголын хувьсгалчид, Ардын намын гишүүд Октябрийн хувьсгалын замнал, оросын ажилчин анги, түүний намын тэмцлийн туршлагыг улс орныхоо өвөрмөц нөхцөлд бүтээлчээр хэрэглэн, хувьсгалын хэргийг зохион байгуулах ардын түр засаг, хувьсгалт тэмцлийг хэрэгжүүлэгч ардын журамт цэргийг байгуулсан юм. Ардын журамт цэрэг ба ард түмний ухамсартай хэсэг нь намынхаа удирдлагаар монгол орныг түрэмгийлэн эзэлсэн Хятадын харгис цэргийн гол хүчийг өвөр Хиагтын газар бутцохиж, улмаар империализмийн бас нэг дуулгавартай зарц цагаантны түрэмгийлэгчдийг Зөвлөлтийн Улаан Армийн тусламжтайгаар сөнөөн уст гаж, эх орноо чөлөөлөн ардын хувьсгалыг мандуулсан билээ 1921

оны Ардын хувьсгалын ялалтаар засгийн эрх ардын гарт шилжсэн юм.

Хувьсгалаар чөлөөлөгдсөн Монголын ард түмэн МАН-ын удирдлагын дор 1921—1924 он хүртэлх хугацаанд ардын төрийн байгууллагыг орон даяар дэлгэрүүлэн бэхжүүлж, төр улс, аж ахуй, соёлоо удирдах хэрэгт оролцож, улмаар БНМАУ-ыг тунхагласан билээ. Хувьсгалын дурдан буй эхний жилүүдэд ардчилал, улс төр, нийгмийн талаар олон тооны хувьсгалт өөрчлөлтүүд эрэмбэ дараатай явагдсаны дотор хамжлагат ёсыг халж феодал ангийн эрх ямбыг хязгаарлаж, ардын амьдралыг дээшлүүлэн, эдийн засагт улс хоршооллын секторын эх үүсгэврийг тавьсан билээ.

Монгол орны капиталист бус хөгжлийн замыг Лениний сургаалд тухайлбал, Ленинээс Монголын төлөөлөгчидтэй уулзахдаа, капитализмыг алгасан, социализм өөд амжилттай хөгжих гол нөхцөл бол нам ба ардын засгийн ажлыг сайжруулах, хоршооллыг дэлгэрүүлэх, аж ахуй, соёлын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх, нам засгийг ард түмнээр хүрээлүүлэх явдал мөн³ гэж сургасанд манай нам тулгуурлан, бүх үйл ажиллагаандаа удирдлага болгосоор ирсэн билээ.

БНМАУ капитализмыг алгасч социализмд шилжихэд Октябрийн орон ЗХУ-ын улс төр, эдийн засаг, цэрэг, соёлын олон талт интернационалч тусламж гарамгай үүрэг гүйцэтгэсэн юм. Монгол, Зөвлөлтийн хооронд 1921 онд байгуулсан найрамдлын хэлэлцээр, 1936 онд байгуулсан харилцан туслалцах тухай протокол, 1946, 1966 онуудад байгуулсан найрамдал, харилцан туслалцах гэрээ зэрэг бусад олон баримт бичгүүдийн дагуу Монгол, Зөвлөлтийн ард түмний найрамдал, хамтын ажиллагаа ямагт өргөжин бэхжиж, монголын тусгаар тогтнолд нэг бус удаа аюул учирч байсан үед Зөвлөлтийн ард түмэн үнэлж баршгүй их тусламжийг үзүүлсэн юм. Манай төрийн тусгаар тогтнолд заналхийлж, 1936 онд Буйр нуур, Булан-дэрс, 1939 онд Халхын голд тус тус цөмрөн орж байсан Японы цэргийг зөвлөлтийн Улаан армийн ангиуд Монголын ардын цэрэгтэй мөр зэрэгцэн бут ниргэж, хөөн зайлуулсныг Монголын ард түмэн ямагт талархан дурсдаг юм. ЗХУ дээрх гэрээ хэлэлцээрийн дагуу тус орны аж ахуй, соёлын хөгжилд өгөөмөр тусламж үзүүлж ирсэн билээ.

1921—1940 он хүртэл үргэлжилсэн хувьсгалын ардчилсан шатанд, цахилгаан станц, аж үйлдвэрийн комбинат, ноос угаах үйлдвэр, төмрийн завод зэрэг улсын хэд хэдэн үйлдвэрийн газар байгуулагдав. Хөдөө аж ахуйд мал эмнэлэг, хадлан тариалангийн техник нэвтэрч сангийн аж ахуй байгуулагдан, ядуу, дунд малчин ардын ахуй байдал сайжирч, ардын аж ахуйг хоршооллох анхны зарим алхмууд хийгдэж, феодал ба чинээлэг ардын эдийн засгийн нөлөөг сулруулах талаар албан татварын бодлогыг явуулах зэрэг хувьсгалт арга хэмжээнүүд хэрэгжсэн билээ. Холбоо харилцаа, авто тээвэр нэлээд хөгжсөнөөс гадна ардын боловсрол, соёл, эрүүлийг хамгаалах талаар багагүй ажил хийгджээ. Хар, шар феодалын хөрөнгийг хурааж, сонгуулийн эрхийг нь хассан явдал феодал ангийн байр суурийг сулруулахад гүн ач холбогдолтой болсон юм. Бас гадаадын мөнгө хүүлэгч худалдаачдыг хязгаарлан улмаар улс орны зах зээлээс шахан зайлуулж, ардын хоршоо ба улсын худалдааг буй болгон бэхжүүлжээ. Ядуу, дунд лам нарыг бурангуй нөлөөнөөс ангижруулж, нийгмийн

тустай хөдөлмөрт оруулсан ба хүүхэд залуучуудыг сургуулиар боловсруулан хүмүүжүүлэх, ард түмний хувьсгалч ухамсарыг дээшлүүлэх талаар намаас явуулсан нийгэм, улс төрийн арга хэмжээнүүд нь Монгол орны эдийн засаг, оюун ухааны хувьд ноёрхож, ард түмнийг мунхруулан, соёлын хөгжилд нь саад учруулж байсан сүм хийдийн үйл ажиллагааг эцэс болгоход хүргэжээ. Дээрх арга хэмжээнүүдийн үрээр феодал ангийг эгнэт устгаж, шинэ ажилчин анги төрж, монгол орон социализмын замд шилжин орох урьдчилсан нөхцөл бүрдүүлэн буй болголоо. МАХН улс орноо капиталист бус замаар хөгжүүлэн социализм байгуулах тэмцэлдээ хувьсгалаар устгагдсан феодал ангийн удаа дараагийн эсэргүүцлийг улс төр, үзэл суртлын талаар няцааж, капиталист бус хөгжлийн зорилтыг хангахын төлөө тэмцэж, шинээр төрж байсан ажилчин анги ба хөдөлмөрч малчдын төлөөлөгчдөөр эгнээгээ өргөтгөн, зохион байгуулалт, үзэл суртлын талаар бэхжиж ирсэн билээ. Үүний зэрэгцээ нам эгнээндээ гарч байсан барууны хэлбэрэл, зүүний нугалаа зэрэг алдаа завхарлуудыг хурцаар шүүмжлэн илрүүлж, зоригтой зассан юм.

Монголын ард түмэн 1940—1961 он хүртэл МАХН-ын удирдлагын дор ЗХУ ба ах дуу социалист орнуудын интернационалч тусламжаар социализм байгуулах олон талт их ажлыг хийж явууллаа. Зөвлөлтийн ард түмнээс Гитлерийн Герман ба түүний хань хамсаатны эсрэг явуулсан эх орны дайны жилүүдэд Монголын ард түмэн намынхаа удирдлагын дор зөвлөлтийн Улаан Армид эд материал, сэтгэл санааны тусламж дэмжлэг үзүүлэн аж ахуй, соёлын зорилтоо хэрэгжүүлж, японы милитаристуудыг бут ниргэсэн чөлөөлөх дайнд манай ардын цэрэг оролцсон нь даян дэлхийд энх тайвныг тогтооход БНМАУ-аас оруулсан чухал хувь нэмэр болсон юм.

Дайны дараа БНМАУ ЗХУ-тай тогтоосон бат найрамдал, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн гүнзгийрүүлж, социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай ах дүүгийн холбоо тогтоож, тэдний интернационалч тусламжийг хүлээж эдийн засаг, соёлоо түргэн хөгжүүлж, ард түмнийхээ аж байдлыг сайжруулах талаар шинэ шинэ амжилтанд хүрсэн юм. Энэ үеийн түүхэн ач холбогдолтой явдлууд бол нийт ард түмнийг бичиг үсэгтэй болгож, ардын аж ахуйг социалист ёсоор хоршоолсон хэрэг юм.

Эдгээрийн үр дүнд 1961 он гэхэд Монгол оронд орчин үеийн аж үйлдвэрийн шинэ, шинэ газрууд байгуулагдаж, хөдөө аж ахуй социалист ёсоор хоршоологдон бэхжин хөгжив.

МАХН-ын IV программын заалтын дагуу тус оронд социализмын материал техникийн баазыг буй болгох зорилгоор аж үйлдвэр, хөдөө аж ахуйгаа цаашид хөгжүүлж, ЗХУ ба ах дүү бусад орнуудын тусламжаар улс ардын аж ахуйн бүх салбарт шинэ гарамгай амжил тууд гарч, Дархан, Эрдэнэт зэрэг аж үйлдвэрийн томоохон хот, хотхон олон тооны суурин, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр, холбоо, соёлын цоо шинэ объектуудыг байгуулсан нь социализмын материал техникийн баазыг байгуулахад түүхэн ач холбогдолтой боллоо. Үүний үрээр түлш эрчим хүч, уул уурхай, их барилга, ой мод, хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарууд өргөжин хөгжиж төмөр зам, авто тээвэр, иргэний агаарын тээвэр, холбоо харилцаа зэрэг салбарууд шинэ амжилтанд хүрлээ.

Ерөнхий боловсрол, тусгай дунд, дээд сургууль, шинжлэх ухаан, соёл урлаг, эрүүлийг хамгаалах байгууллагуудын тоо олширч, үйл

ажиллагааны нь чанар сайжирч, ард түмний материаллаг ба соёлын амьдралын түвшин дээшилсээр байна.

МАХН-ын XIX их хурлаас дэвшүүлсэн зорилт ба таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн тулд манай ард түмэн ихийг бүтээж байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг 2000 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны программ тус дөхөм болох юм.»⁴ гэж МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ж. Батмөнх МАХН-ын XIX их хуралд тавьсан тайлан илтгэлдээ цохон дурджээ.

Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх VII таван жилийн төлөвлөгөөний гарааны жил -1986 оны төлөвлөгөөт зорилт үндсэн үзүүлэлтээрээ биелэгдэв. Жишээ нь үндэсний орлогын үйлдвэрлэл 5,6 хувь, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх таван жилийн дунджаас 12 хувь тус тус өсч, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 102,6 хувиар биелэгджээ.⁵ Улсын нийт малын тоо толгой 1985 оныхоос 158,3 мянгаар өсч, 1986 онд үр тариа хураан авах төлөвлөгөөг 16 хувь давуулан биелүүлэв. Соёлын салбарын төлөвлөгөөт үзүүлэлтүүд мөн урьд оныхоос өсөн нэмэгдлээ.

Монголын ард түмэн ЗХУ-тай байгуулсан уламжлалт ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, социалист байуулалтдаа шинэ шинэ амжилтанд хүрч, дайны эсрэг, энх тайвны төлөө тэмцлээ идэвхжүүлж Аугаа их Октябрийн социалист хувьсгалын 70 жилийн ойг угтан тэмдэглэх гэж байна.

III

Зүүн Европын хэд хэдэн оронд ардын ардчилсан хувьсгал ялсанаар дэлхийн социалист систем бүрэлдэн тогтлоо.

Хүн төрөлхтний гуравны нэгээс илүүг хамарсан дэлхийн социалист систем эдүгээ хөгжингүй эдийн засаг, шинжлэх ухааны ихээхэн бааз суурь, цэрэг, улс төрийн найдвартай потенциалтай болж, улам боловсронгуй болон хөгжсөөр байна.⁶ гэж ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев ЗХУКН-ын XXVII их хурал дээр тавьсан илтгэлдээ цохон тэмдэглэсэн билээ.

Империалист Япон улс дэлхийн дайны сүүлчийн шатанд улс төр цэргийн талаар бут цохигдсон нь Азийн ард түмний хувь заяанд гүн ач холбогдолтой болсон юм. Үүний үрээр Вьетнам, Хойд Солонгос, Хятадад ардчилсан хувьсгал мандаж, эдгээр орнууд социализмд шилжин орж хөгжих бололцоотой болсон юм. Одоо Лаос, Кампучи улсууд мөн ийм замаар хөгжиж байна. Азийн социалист орнууд ЗХУ, Европын социалист орнуудын ах дүүгийн интернационалч тусламж, дэмжлэгээр нийгэм, эдийн засгийн хоцрогдолтой холбогдсон саад бэрхшээлийг даван туулж социализмыг амжилттай байгуулж байна

Ази, Африк, Латин Америкийн олон орнууд империализмын колоничлолын дарлалаас ангижран тусгаар тогтнолоо байлдан авч, нийгэм, эдийн засгийн дэвшлийн төлөө тэмцэж байна.

4 Ж. Батмөнх, Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг. I боть, Улаанбаатар. , 1986, 653-р тал

5 «Үнэн» 1987. I, II.

6 Материалы XXVII съезда Коммунистической партии Советского Союза.

Москва., 1986, 7-р тал.

Латин Америкт социалист Куба улс тогтнож, хөгжин цэцэглэж байгаагийн зэрэгцээ Никарагуа, Афганистан зэрэг орнууд империалист гүрнүүдийн харгис өнгөлзлөгийн хүнд нөхцөлд өөрийн орны тусгаар тогтнолыг бэхжүүлэн нийгэм, эдийн засгийн талаар хувьсгалт өөрчлөлтүүд хийж байна. Колонийн дарлалаас чөлөөлөгдсөн орнуудын дотроос 20 орчим улс социалист чиг баримжааг сонгон авч империализмын шинэ колониололын эсрэг тэмцлийг явуулж, улс орондоо нийгэм, эдийн засгийн ардчилсан хувьсгалт өөрчлөлтүүдийг зохион явуулж байна. Эдгээр орнуудын хөгжлийн зам Зөвлөлтийн Дундад Азийн улс орнууд ба Монгол орны капиталист бус хөгжлөөс Олон улсын байдал ба нийгэм, эдийн засгийн талаар өвөрмөц онцлогтой боловч капиталист бус хөгжлөөр замнан социализмд шилжин орох тухай Маркс, Энгельсийн сургаалын ерөнхий зүй тогтлын дагуу хөгжиж байна.

Дээр өгүүлсэн бүхэн нь Аугаа их Октябрийн социалист хувьсгалын үр нөлөөгөөр даян дэлхийд үүр цайж, үй олон зуун сая үгээгүй нарын аз жаргалын зам тэлж нээгдсэний гэрч мөн.

IV

БНМАУ ЗХУ болон ах дүү социалист орнууд, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөнтэй интернационалч хамтын ажиллагаа, эв санааныхаа нэгдлийг цаашид бэхжүүлэн Ази, Африк, Латин Америкийн ард түмний тусгаар тогтнол, эрх чөлөө, нийгмийн дэвшлийнхээ төлөө явуулж буй тэмцлийг дэмжиж байна.

Империализм түүний хамгийн харгис хүчин АНУ, НАТО-ийн бүлгийнхнээс явуулж буй дайнч түрэмгий бодлого нь манай эрин үеийн олон улсын харилцааг ноцтой хурцатгаж байна. Иймээс газар дэлхийг цөмийн зэвсэггүй болгох, хүн төрөлхтнийг эсэн мэнд байлгах асуудал нийт хүн төрөлхтний язгуур эрх ашигт нийцэж байгаа юм. ЗХУ ба социалист орнууд бүх нийтийг хамарсан аюулгүй байдлыг олон улсын харилцаанд тогтоож, нийгэм, улс төрийн талаар өөр өөр байгуулалтай улс орнуудын хооронд энх тайвнаар зэрэгцэн орших ленинч зарчмыг удирдлага болгож байдаг билээ. ЗХУ Цөмийн зэвсэгийг 2000 он гэхэд устгах программ, уг зэвсгийг турших ажлыг зогсоох санаачилгаас гадна ердийн зэвсэглэлийг хорогдуулах ба химийн зэвсгийг эгнэгт хорих зэрэг олон чухал энх тайванч санал, санаачлагуудыг дэвшүүлэн түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө тууштай тэмцэж байна. Энэ бол Аугаа их Октябрийн хувьсгалын дараа Зөвлөлт төрөөс гаргасан найрамдлын тунхаглалын шууд үргэлжлэл бөгөөд нийт хүн төрөлхтний үндсэн ашиг сонирхолд зохицсон хамгийн хүнлэг бодлого юм. Үүнийг Варшавын гэрээний болон социалист хамтын нөхөрлөлийн бүх орнууд, тухайлбал, БНМАУ, дэвшилт хүн төрөлхтөн, энхийг эрхэмлэгч бүх хүчин дэмжиж байна. Гэтэл Америкийн Нэгдсэн Улс түүний хань хамсаатнууд зэвсгээр улайран хөөцөлдөж, цэргийн хүчээр давамгайлахын тулд оддын дайнд бэлтгэхээр бүх хүчээрээ чармайж байна. Тэд энхийн эсрэг энэ түрэмгий бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор ЗХУ ба социалист хамтын нөхөрлөлийн орнуудын энх тайванч санаачлагад зүйл бүрийн саад тотгор учруулж, бусад орны нутагт цэргийн баазаа олшруулан, цөмийн зэвсэгт пуужин, онгоц хөлөг дэлхийн янз бүрийн газар нутагт байрлуулан зоож, зарим бүс нутагт зэвсэгт мөргөлдөөнийг өдөөж, тусгаар тогтносон орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс дур зоргоороо оролцож, олон улсын байдлыг улам бүр хурцатган даян дэлхийн энх тайванд заналхийлж байна.

АНУ ба түүний хань хамсаатны түрэмгийлэл, цөмийн зэвсгээр хөөцөлддөг бодлогыг даян дэлхийн олон миллиард хүмүүс газар сайгүй эсэргүүцэж, зөвлөлтийн энх тайванч бодлогыг тууштай дэмжиж байна.

Энх тайвны энэ их тулалдааны тэргүүн эгнээнд Октябрийн хувьсгалын эх орон - ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орнууд, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөн явж байна. Энэ тэмцэлд нам, төрийнхээ энх тайванч бодлогыг сайшаан дэмжиж байдаг монголын ард түмэн, манай олон нийт мөн идэвхтэй оролцож байгаа юм. Дайны эсрэг, энх тайвны төлөө өргөн олон түмний тэмцэл идэвхжиж буй нь Аугаа их Октябрийн үзэл санааны шинэ яруу тод илрэл мөн.

ЭНЭТХЭГ УЛСЫН ЭНХ ТАЙВАН, ДЭВШИЛ ХӨГЖЛИЙН 40 ЖИЛ

Д. Пүрэв

Энэтхэг орныг манай ард түмэн эрт дээр үеэс сайн мэддэг бөгөөд түүх соёлын мянган жилийн гайхамшигт уламжлалыг нь хүндэтгэж иржээ.

Өнөөдөр Энэтхэгийн 328 сая ам дөрвөлжин км нутагт 750 сая¹ хүн ам оршин сууж байна. Энэтхэг орон бол Азийн эртний түүхт олон үндэстэн, ястны өлгий нутаг, хүн төрөлхтний соёл, иргэншлийн томхон төв юм. Одоогоос 3000 гаруй жилийн тэртээд үндэс суурь нь тавигдсан Энэтхэгийн соёл иргэншил хүн төрөлхтний түүх соёлд арилшгүй тод ул мөрөө үлдээжээ. Энэтхэгийн ард түмэн түүхэн урт удаан хөгжлийнхөө явцад эдийн болоод оюуны соёлын асар их баялагийг бүтээсэн төдийгүй, өөрийн соёлоороо бусдыг өөртөө татах их хүчийг бий болгожээ. Энэтхэгийн соёл, урлагийн бас нэг онцлог нь харийн ард түмний соёлын өв уламжлалын аль үнэ цэнэтэйг өөртөө шингээж авахдаа өвөрмөц шинж төрхөө ямагт хадгалан үлдэж байсан явдал юм. Түүхийн хөгжлийн бүр эхэн үеэс уламжлагдаж ирсэн Энэтхэгийн соёлын төвүүд нь Инд, Ганга мөрний сав, Маханади, Годавари, Кришна, Өмнөд Энэтхэгийн Кавари зэрэгт байдаг бөгөөд энд оршин суугчид эрт дээр үеэс аж ахуйгаа эрхлэн явуулах онцгой хэвшил, арга барилтай байсан төдийгүй Хинду шашны сургаал номлолд тулгуурласан нийгмийн институттай байжээ.²

XVIII зуунд Энэтхэгт ноёрхолоо тогтоосон Британий колонийн дэглэх Энэтхэгийн нийгэм, түүх, соёлын хөгжлийг хойш татах болов. Британийн колоничлогчид Энэтхэгт зөвхөн улс төрийн ноёрхолоо тогтоосон төдийгүй, колоничлогчдын техникийн «Шинэ соёл» нь энэтхэгчүүдийн олон үеийн амьдралын уламжлалт хэвшлийг эвдэж, феодалын нийгмийн эдийн засгийн бүтэц (хөдөө аж ахуй, үйлдвэр-гар урлал, худалдаа, уран сайхны урлал) -ийн үндсийг бусниулжээ. Засаг захиргаа, нийгмийн байгууламжийн уламжлалт бүтэц колонийн эзэнт

1 «За рубежом» No 4, 1987.

2 Страны и Народы (Южная Азия) «Мысль» 1982. с. 31–33.